

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ХОРЬДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны зургаадугаар сарын 04-ний 14 цаг 20 минутад эхэлж, 15 цаг 52 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 32 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Зарим удирдах албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"><li>- Үндсэн Хуулийн Цэцийн Тамгын газрын Хамтын ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтсийн даргын албан тушаалд</li><li>- Хууль зүйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын даргын албан тушаалд</li><li>- Зам тээврийн яамны Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд</li><li>- Зам тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын даргын албан тушаалд</li></ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Норовсүрэнгийн Соронзонболдыг Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын Хамтын ажиллагаа, мэдээллийн хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган, нэр дэвшүүлж, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Гомбодоржийн Цэцгээг Хууль зүйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ,</p>

дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган, нэр дэвшүүлж, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

Төмөрбаатарын Зулзүсэмийг Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

Дашдоржийн Доржхандыг Зам, тээврийн яамны Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн

		албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Сүхбаатар аймгийн нутгийн захиргааны байгууллагын болон Барилга, хот байгуулалтын яамны төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 05 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд Сүхбаатар аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 04 -ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Сүхбаатар аймагт 2015 оны 05 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 13 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 10 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 3 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 5 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 4 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 9</p>

нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөл /Ц.Лхамсүрэн/-д үүрэг болгох

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 04 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :

1. Барилга, хот байгуулалтын яамны төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 3 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх.

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар

		<p>хавсралтад дурдсан нэр бүхий 2 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>3. Нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилохыг Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Төрийн албаны зөвлөлийн Гадаад харилцааны яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Гадаад хэргийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай асуудлыг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга томилогдох хүртэл хойшлуулахаар шийдвэрлэлээ.</p>
4	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхөөр 2009-2013 онд ажиллаж байсан Э.Зоригтыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхийн албан тушаалд 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хооронд томилогдон ажиллаж байсан Эрдэнэчулууны Зоригтыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

5	<p>"Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3 дахь заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 1.7, 6.4, "Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлт гаргах заавар"-ын 3.1, 3.1.1, 3.1.5, 6.1 дэх заалтыг дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулах.</p> <p>1. Журмын 1.7, зааврын 6.1, 3.1.1, 3.1.5 дахь хэсэгт</p> <ul style="list-style-type: none"> <li>- Журмын 1.7-д ...“сүлжээний дэд бүтцийн” гэсний дараа “бэлэн байдлыг хангаж” гэж,</li> <li>- Зааврын 6.1-д “хамгийн өндөр үнэлгээ авсан” гэсний дараа “нэг” гэж</li> <li>- Зааврын 3.1.1 болон 3.1.5-д ...“шалгалтыг” гэсний дараа “зөвхөн” гэж тус тус нэмэх</li> </ul> <p>2. Зааврын 3.1, 6.1 дэх хэсгийг</p> <ul style="list-style-type: none"> <li>- 3.1 ... дор дурдсан “аргуудаас” гэснийг “аргуудаар” гэж,</li> <li>- 6.1”Комисс ...сонгон” гэсний дараа “шалгаруулалтад” гэснийг “шалгаруулалтаар” гэж тус тус өөрчлөх</li> </ul> <p>3. Журмын 1.7, 6.4 зааврын 3.1.1 3.1.5, 6.1 дэх заалтуудаас дараах хэсгээс</p> <ul style="list-style-type: none"> <li>- Журмын 1.7-д ...”сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр явуулах” гэсний өмнөх “хувьд боломжтой бол” гэснийг,</li> <li>- Журмын 6.4 ...” онооны дарааллаар байр эзлүүлэн”</li> </ul>
---	--	--

		<p>гэсний дараах "жагсааж, тэнцсэн нэр дэвшигчдийн" гэснийг</p> <ul style="list-style-type: none"><li>- Зааврын 3.1.1 болон 3.1.5-д ... "цахим сүлжээ ашиглах", гэсний дараах "цахим сүлжээ ашиглах боломжгүй тохиолдолд сорил, сорилын хуудас (карт) бөглөх," гэснийг,</li><li>- Зааврын 3.1.5-аас компьютер дээр даалгавар гүйцэтгүүлэх гэснийг</li><li>- Зааврын 6.1 .. "хамгийн өндөр үнэлгээ авсан иргэнийг гэсний өмнөх "тэнцсэн сонгон шалгаруулалтад оролцогчийг төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэх тухай зааврын 5.1-д заасны дагуу үйлдсэн нэгдсэн жагсаалтаар" гэснийг хасах</li></ul> <p>4. Энэхүү тогтоолыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд зөвлөмжийн хамт хүргүүлэн холбогдох байгууллагуудад мэдээлэхийг Ажлын алба /С.Цэдэндамба/-нд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---